

УДК 930.85+398.8

ОРОСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТЭН К. Н. ЯЦКОВСКАЯ БА ТҮҮНИЙ ОЙРАД АРДЫН ДУУНЫ ТАЛААРХ СУДАЛГААНЫ СОЁЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Өрнөхдэлгэр Д.

Ховд их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Хэл зохиолын тэнхим. Хэл бичгийн ухааны доктор, профессор.
E-mail: urnukhdelger.d@gmail.com

Бүрэнцол

Дундад улсын Ланжоу дахь Баруун хойтын үндэстний их сургуулийн
Дундад улсын Хэл утга зохиолын хэлтсийн 2021 оны аспирант.
作者: 布仁曹洛, 男, 中国·兰州·西北民族大学中国语言文学学部2021级硕士研究生。
E-mail: 1300579540@qq.com

Хураангуй

Энэхүү өгүүлэлд Оросын Холбооны Улсын эрдэмтэн К. Н. Яцковскаягийн Монгол судлалын бүтээл, тэр дундаа Ойрад ардын дууг хэрхэн тэмдэглэж, судалсан талаар Ойрад Монголын хэл соёлын онцлогтой уялдуулан авч үзжээ. Монголч эрдэмтэн К. Н. Яцковская 1988 онд «Монгол ардын дуунууд» гэсэн судалгааны ном хэвлүүлжээ. Тус зохиол нь дууны судалгаа болон дууны текст гэсэн хоёр ангиас бүрэлдэж байна. Судалгааны ангид нь ардын дуучид, ардын дуу, ардын дууны мотив, дууны дүрслэлийн арга барил болон ардын аман яруу найраг хийгээд орчин үеийн яруу найргийг харьцуулан судалсан байна. Тус ном нь судалгаанаас гадна ардын дууны текстүүд, ардын дууны орос орчуулга, ардын дууны хэлхээ, сурвалжилсан дуучдын нэрсийн жагсаалт, үгсийн тайлбар болон ном зүй гэх мэт хэсгүүдээр бүрэлдсэн байна. Дууны текст нь зохиогчийн Монгол улсын Ховд болон Увс зэрэг аймгуудаас цуглуулсан 219 ойрад ардын дуу орсон бөгөөд тэрхүү дуунуудаа монгол кирилл үсгээр тэмдэглэсэн байна. Мөн түүнчлэн энэхүү дуунуудаасаа 37 дууг сонгон орос хэлээр орчуулжээ. Судлагчийн хийсэн энэ судалгаа нь нэлээд дорвитой сайн судалгаа болсон бөгөөд хойно дагалдуулсан 219 ардын дуу нь ч монгол ардын дуу судалж байгаа дэлхийн олон эрдэмтдэд тун ч үнэ цэн бүхий эх хэрэглэгдэхүүн болсоор байна.

Түлхүүр үгс

К. Н. Яцковская, Оросын монгол судлал, соёлын ач холбогдол, ойрад ардын дуу, нутгийн аялгуу.



UDC 930.85+398.8

RUSSIAN MONGOLIST K. N. YATSKOVSKAYA AND THE CULTURAL SIGNIFICANCE OF HER STUDY OF OIRAD FOLK SONGS

Urnokhdelger D.

Doctor of Linguistics, Professor.

Department of Linguistics, School of Social Sciences and Humanities, Hovd University.

E-mail: urnukhdelger.d@gmail.com

Burentsol

2021 graduate student in the Department of Chinese Language and Literature Department, Northwest National University, Lanzhou, China.

作说: 布仁曹洛, 男, 中国·兰州·西北民族大学中国语言文学学部2021级电影研究生。

E-mail: 1300579540@qq.com

Annotation

In this article, the scientist of the Russian Federation K. N. Yatskovskaya's work on Mongolian studies, including how she recorded and studied Oirad folk songs, was discussed in relation to the characteristics of Oirad Mongolian language and culture. Mongolist K. N. Yatskovskaya in 1988 published a research book called "Mongolian folk songs". The text consists of two parts: song study and song text. In the research class, folk singers, folk songs, motifs of folk songs, methods of song description, folk poetry and modern poetry were compared. In addition to research, the book is composed of folk song texts, Russian translations of folk songs, folk song chains, a list of the names of singers covered, explanations of words, and bibliography. The book contains 219 Oirad folk songs collected by the author from Khovd andUvs provinces of Mongolia, and those songs are written in Mongolian Cyrillic letters. Also, 37 songs were selected from these songs and translated into Russian. This book has become a significant and good research, and the 219 folk songs that followed are still very valuable source materials for many scholars of the world who are studying Mongolian folk songs.

Keywords

K. N. Yatskovskaya, Russian Mongolian Studies, cultural significance, Oirad folk songs and local dialects.

О Р Ш И Л

Орчин үеийн дэлхийн Монгол судлалд Оросын Монгол судлалын түүх чухал байр суурь эзэлдэг билээ. Н. Я. Бичурин, О. М. Ковалевский, Д. Банзаров, В. П. Васильев, А. М. Позднеев, Б. Я. Владимирцов нарын шинжлэх ухааны бүтээлч чанарыг өвлөн уламжилж, Оросын нэрт монголч эрдэмтэн К. Н. Яцковская энэ салбарт томоохон хувь нэмэр оруулсан юм. Монгол орчин үеийн уран зохиолоор судалгаагаа эхлүүлсэн К. Н. Яцковская 1972 онд Д. Нацагдоржийн намтар уран бүтээлээр дэд эрдэмтний зэрэг хамгаалж, улмаар 1978 онд «Д. Нацагдоржийн орчуулгын ур чадварын тухай асуудалд» (Д. Нацагдоржийн уран бүтээлийн тухай) өгүүлэл, 1974 онд «Дашдоржийн Нацагдорж» гэсэн нэгэн сэдэвт бүтээлийг (Яцковская, 1974) хэвлүүлжээ. Тэрээр монголын орчин үеийн уран зохиолоос орос хэл рүү орчуулах, тэдний зохиол бүтээлийг танилцуулах судлах ажилд өөрийн нэгэн насны амьдралаа зориулсан билээ.

Монголч эрдэмтэн Л. Г. Скородумова түүний эрдэм судлалын ажлыг үнэлэн «К. Н. Яцковскаягийн монголын утга зохиолын чиглэлээр хийсэн системтэй судалгаа нь Монголын утга зохиолыг үндэслэгчийн бүтээлд зориулсан диссертацийн ажлаар эхэлсэн нь нүдээ олсон хэрэг байв. Энэхүү монографи өнөөдрийг хүртэл амьдрал, ажлын талаарх цорын ганц, орос хэлээрх бүрэн мэдээллийн эх сурвалж хэвээр байна» гэж онцлон тэмдэглэжээ (Скородумова, 2017: 19).

К. Н. Яцковскаягийн шинжлэх ухааны зам мөрийн томоохон хэсэг нь ойрад-монгол дууны судалгаатай холбоотой байдаг. Зөвлөлт-Монголын эрдэмтдийн хамтарсан ардын аман зохиолын экспедицид (1972, 1979, 1980) оролцсоны үр дүнд Клара Николаевна «Монгол ардын дуу» (1988), «Дархад Г. Даваажийгийн зуун дуу» (1978) гэсэн хоёр ном бичиж хэвлүүлсэн.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Монголч эрдэмтэн К. Н. Яцковскаягийн эрдэм судлалын ажил

Монголч эрдэмтэн К. Н. Яцковская монгол уртын дууны талаар дархад Даваажий ба түүний дуулсан зуун дуу, дөрвөд дууны хөх дэвтэр болон Хархүүгийн Гүнзэнгийн дууны урын сан зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлжээ.

1988 онд «Монгол ардын дуунууд» гэсэн судалгааны ном хэвлүүлжээ. Тус зохиол нь дууны судалгаа болон дууны текст гэсэн хоёр ангиас бүрэлдэж байна. Судалгааны ангид нь ардын дуучид, ардын дуу, ардын дууны мотив, дууны дүрслэлийн арга барил болон ардын аман яруу найраг хийгээд орчин үеийн яруу найргийг харьцуулан судалсан байна. Тус ном нь судалгаанаас гадна ардын дууны текстүүд, ардын дууны орос орчуулга, ардын дууны хэлхээ, сурвалжилсан дуучдын нэрсийн жагсаалт, үгсийн тайлбар болон ном зүй гэх мэт хэсгүүдээр бүрэлдсэн байна. Дууны текст нь зохиогчийн Монгол улсын Ховд болон Увс зэрэг аймгуудаас цуглуулсан 219 ойрад ардын дуу орсон бөгөөд тэрхүү дуунуудаа монгол кирилл үсгээр тэмдэглэсэн байна. Мөн түүнчлэн энэхүү дуунуудаасаа 37 дууг сонгон орос хэлээр орчуулжээ. Судлагчийн хийсэн энэ судалгаа нь нэлээд дорвитой сайн судалгаа болсон бөгөөд хойно дагалдуулсан 219 ардын дуу нь ч монгол ардын дуу судалж байгаа дэлхийн олон эрдэмтдэд тун ч үнэ цэн бүхий эх хэрэглэгдэхүүн болж өгсөн юм.

Монгол Улсын ШУА-ийн хэл зохиолын хүрээлэн, ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэн хамтран “Монгол ардын уртын дуу” бүтээлийг хэвлүүлэн гаргаж Монгол ардын уртын дууны өвөрмөц онцлогийн талаар дэлгэрэнгүй өгүүлж, уртын дууг дотор нь “Найр хуримын магнай дуу”, “Уртын дуу”, “Найр хурим жаргаах дуу” гэсэн гурван том бүлэгт хуваан нийтдээ 277 дууг оруулан хэвлэхдээ бүлэг бүрд Ойрадын дуунаас сорчлон оруулжээ. Ингэхдээ судлаачид монгол ардын уртын дууны тусгай онцлогийг тодорхойлогч нэг гол зүйл нь зан үйлийн зориулалт буюу айзам уртын дууг найр хуримын үед дуулж ирснийг баримтлан дууг сонгон бүлэг болгожээ.

2. Ойрад ардын уртын дууны зан үйлийг сурвалжлан судалсан нь:

Монгол ардын дуу олон зууны тэртээгээс хөгжин уламжлагдаж ирэхдээ Төв Азийн нүүдэлчдийн дундаас ялгаруулах өвөрмөц шинжийг өөртөө шингээн, дэлхий ертөнцийн энгээр Монголыг дуурсгах их хүчийг олсон билээ. Монголчууд уртын дууг үргэлж хүндэтгэн дээдэлж, өр зүрхний чин үнэн санааг илэрхийлдгийн учир мартаж гээлгүй явсаар оюун санааны нуршгүй хана хэрмээ болгосон юм. Чухам иймээс академич Б. Ринчен уртын дууг хүмүүний мэдрэмжийг хөгжүүлж, бодлыг гэгээрүүлж, амьдралыг аз жаргалтай болгох чанараар нь «Мөнхийн зууных» гэжээ.

Зөвлөлтийн болон монгол эрдэмтдийн хоорондын шинжлэх ухааны хамтын ажиллагааг өргөжүүлсний үр дүнд Зөвлөлтийн эрдэмтдэд монголын экспедицид оролцох боломжууд нээгдэж монголын ард түмний аман зохиолыг судлах ажлыг дотоодын монгол судлалд бий болгосон чиглэлийг үргэлжлүүлэн хөгжүүлэх боломж гарсан байна. 1980 онд Зөвлөлт-Монголын ардын аман зохиолын экспедици баруун хойд бүс нутагт явж, тэдний маршрут Б. Я. Владимирцовын экспедицийн үеэр Ховдын хязгаарт багтдаг байсан Увс, Ховд аймгийн сумуудаар явж байсан. Монголын ард түмний баруун хязгаарыг бүрдүүлж байсан овог аймгуудын үр удам манай судалгааны гол мэдээлэгчдийг бүрдүүлсэн. Тэдгээрээс бичсэн (250 хувилбартай) дуунууд нь Баруун Монголчуудын дууны ертөнцийн бүрэн дүр зургийг бүрдүүлдэг. Олон дууг анх удаа шинжлэх ухааны эргэлтэд оруулсан болно.

Баруун хойд аймгуудын нутаг дэвсгэр Увс, Ховдын газруудаар явж дууны материал цуглуулах, уламжлалт өв соёлыг илрүүлэх, урьд нь хуучин гэж нэрлэдэг байсан дууны үгийн өөрчлөлтийн шинж чанар, арга хэлбэрт дүн шинжилгээ хийх нь бидний зорилго байсан. Эртний дууны өв уламжлалыг тээгчид болох орчин үеийн ардын дууны дуучид, сайн дурын уран сайханчдын талаарх дүр зургийг гаргах, орчин үеийн монгол яруу найргийг ардын дуутай холбож үзэх нь монголчуудын урлагийн уламжлалыг үргэлжлүүлэх тал дээр чухал ач холбогдолтой хэмээн үзсэн билээ.

Дуу тэмдэглэж авсан хүмүүс гэвэл, **Увс аймгаас Давст сумын** Намдаг Мухулцугийн, 71 нас¹, дөрвөд, тэтгэвэрт (1,1-1,54), Пэлжээ Ядамын, 69 нас, дөрвөд, тэтгэвэрт (1,1-1,54), Ичинхорлоо Сэвтэрийн, 21 нас, дөрвөд, музейн ажилтан (2,1-2,5), Мижид Баяны, 59 нас, дөрвөд, сумын төвийн оршин суугч (3,1-3,5), Лүүрэв Хөхөөн, 68 нас, дөрвөд, тэтгэвэрт (4,1-4,5), **Сагил сумын** Гүнзэн Хархүүгийн, 54 нас, дөрвөд, хоньчин (5,1-5,81), Жамбал Шалуугийн, 63 нас, дөрвөд, тэтгэвэрт (6,1-6,5), Долгор Буяны, 49 нас, дөрвөд, гэрийн эзэгтэй (7,1-7,5), **Бөхмөрөн сумын** Маш Шандайн,

¹Дууны үгийг бичиж авсан үе буюу 1980 онд ийм настай байсан болно.

52 нас, дөрвөд, манаач (8,1-8,18), Батчулуун Нянгарын, 65 нас, дөрвөд, холбоочин (9,1-9,2), Жиргээ Баянбилэгийн, 66 нас, дөрвөд, хоньчин (10,1-10,14), **Ховд аймгаас Дуут сумын** Сүрэн Содовын, 70 нас, урианхай, тэтгэвэрт (11,1-11,3), Дорж Чоймболын, 27 нас, урианхай, дархан (12,1-12,3), Хорлоо Баярхүүгийн, 32 нас, урианхай, тогооч (13,1-13,2), Дамдинсүрэн Мэндбаярын, 39 нас, урианхай, Үйлдвэр бригадын гишүүн (14,1), **Ховд хотоос** Нямсүрэн Жамбын, 31 нас, өөлд, Хөгжимт драмын театрын гоцлол дуучин (15,1-15,11), **Мөст сумаас** Бэгзжав Гомбожавын, 66 нас, халх, тэтгэвэрт (16,1-16,3), Хархүү Очирын, 53 нас, захчин, анчин (17,1-17,4), Лхасүрэн Баарайн, 49 нас, халх, барилгачин (18,1-18,3), Лхамжав Цэрэннадмидын, 45 нас, халх, Хөдөө аж ахуйн газрын түүхий эдийн баазын дарга (19,1-19,3), **Манхан сумаас** Бадам Галданы, 65 нас, захчин, манаач (20,1-20,20).

Ойрадын ардын дууг зан үйлийн зориулалт, түүхэн гарал, хувирал өөрчлөлт, тархац онцлогийн талаар угсаатны судлаачид багагүй судалгаа хийсэн байна. Энэ чиглэлийн хамгийн дорвитой бүтээл бол “Монгол улсын угсаатны зүй” ботиуд юм. Монгол улсын угсаатны зүйн II ботид дөрвөд, өөлд, торгууд, баяд, алтайн урианхай, захчин, мянгадын талаар тус бүрд нь тусгай бүлэг болгон авч угсаа гарал, аж ахуй, соёлын талаар өгүүлэхдээ ардын дууны онцлогийг нь тодорхойлохыг оролдсон байна. Тухайлбал: дөрвөдөд найрыг “Нарийн баахан шарга” дуугаар эхэлдэг, найрын төгсгөлд голдуу “Урт сайхан хүрэн” гэдэг дууг дуулдаг, өөлд ардын дууны зонхилох сэдвийн нэг бол сургаалийн дуу, торгууд ардын дууны үлэмжхэн хэсгийг шог хошин дуу буюу аман мэдээнд өгүүлдэгчлэн “Харганын дуу” эзэлдэг, баядад гэрийн бүрлэгийн найр дээр “Сэтэрт баахан шарга” гэдэг дууг дуулдаг энэ дуунд хүн хүнээ сэтгэлийн сайнаар эрхэмлэж хүндлэх, гэр орноо яс модны чанараар барих тухай үнэн бодит байдлыг тусгасан, алтайн урианхайн уртын дууг халх нутгийн уртын дуутай харьцуулж үзвэл хөг аялгууны хувьд арай богиновтор айзамтай.

Баруун монголчуудын зохиосон ихэнх дуу нь найранд дуулагддаг тул зан үйлийн дуунд хамааруулдаг. Зан үйлийн бус дуунууд ч тодорхой хувийг эзэлнэ. Гэсэн хэдий ч дууны ардын аман зохиолын өөрчлөлтийн үйл явцад дуунууд зан үйлээс зан үйлийн бус хэлбэрт шилжсэн байдаг. В.Я. Пропп уянгын шинжтэй болсон хуримын дууг хуримын ёслолын үед дуулахаа больсон (1976: 4) гэж тэмдэглэжээ. Тиймээс найрын дууг зан үйлийн дуу гэж үзэх нь харьцангуй бага байдаг.

Найрын зан үйл нь өөрийн гэсэн хатуу дэг жаяг, ёс зүй, хориглох дүрэмтэй байдаг. Найран дээр дуулагддаг уртын дуунууд бас өөрийн гэсэн дэг жаягтай; найрын эхэнд, төгсгөлд дуулдаг дуунуудыг нарийн тодорхойлдог. Газар газрын ястан угсаантнууд өөрсдийн найр эхлүүлэх дуу, заавал даган дуулах дууны цомогтой байдаг. Мөн найрын ураг барилдах ёслолын дуу ч байдаг байна. Тухайлбал Сагил суманд найраа “Ут сайхан хүрэн” (5, 1) дуугаар эхэлдэг.

Ут сайхан хүрэн

Уужмын хаалгаар мэгшинэ

Уйдашгүй та нартайгаа

Найрлан сууж жаргана

Найранд ирсэн олон зочдын баяр баясгаланг илэрхийлсэн утга бүхий өөр бас хоёр бадаг шүлэг бий. Яг энэ дуу Х. Гүнзэнгийн нутаг нэгт Ш. Жамбалын урын санд байдаг. Гэхдээ түүний мэддэг хоёр бадаг нь Гүнзэнгийн хувилбартай төстэй юм.

“Ут сайхан хүрэн” (6, 4) дууг өөлдүүд дуулдаг. Өөлдүүдийн хувьд энэ дуу нь хуримынх байсан ба одоо уянгын дуу болжээ. Дуунд харь газар мордуулсан залуу бүсгүйн уй гунигийн тухай өгүүлдэг.

Найрын зочдыг баяр хөөрөөр бялхам байхыг ерөөн “Сав их ертөнц» (1, 25) дууг барьдаг байна. Энэ дуу баяр бахдалтайгаар эхлэн,

Сав их ертөнцийн

Наран сар тунгалаг

Сайхан дөрвөн цагт

Зуны сар үлэмж

гэрийн эзний зүүн талд гэрийн баруун хэсгийг эзлэн суугаа нүдэндээ баярын нулимстай хүчирхэг барсын дүртэй эрчүүдээс эхлэн гэрийн эзний баруун талд гэрийн зүүн хэсгийг эзлэн суух нүдэндээ хайр энхрийлэл гийгүүлсэн үзэсгэлэн төгөлдөр бүсгүйчүүдийн тухай дуулагдана. Энэ дууны гол утга нь “Бүгд хамтдаа баярлан цэнгэх тухай” юм. Найрчдын дунд сөнөчид чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэд ёс жаягийг хамгийн сайн мэдэх төдийгүй хэзээ сөн түшихийг, хэзээ, хэнд, ямар дарааллаар барих зэрэг нарийн ширийн зүйл болгоныг мэддэг. Энэ дуунд хамгийн хүндтэй зочдын дараа сөнчдийг онцолсон байдаг.

“Зэрэгийн шар хулс” (20,14) бол найрчдад зориулсан захчин түмний мэндчилгээний дуу юм.

Зэрэгийн шар хулс нь

Зэгзээлэн дүнхийж харагдана

Зэрэглэсэн олон ах нартайгаа

Найрлан хамт жаргана

Дараагийн бадагт хоёр мөр зэрэгцэн орсон байх ба эхнийх нь зэгсний олон төрлийг дурдсан байхад, хоёрдугаарт нь олон зовлон бэрхшээлийг хамтдаа даван туулсан хүмүүсийн төлөөллийг дурджээ.

“Өндөр Хөхийн элхэн” (5,40) дуунд уул нуруу, тал хөндийгөөс найранд ирсэн ахмад буурлууд хамаатан саднаа угтах, үдэхдээ энэхүү дуугаа өргөдөг тухай өгүүлжээ.

Найрыг эхлүүлэх, жаргаах уламжлал нь газар газарт өөрийн онцлог шинж чанарыг агуулсан байдаг. Хуур эгшиглэсний дараа найр эхэлсэнийг зарлаж, найр эхлэх ёслол болсны дараа дайллага цайллага өрнөж дахин дуу хуураар түрнэ. Найрын дунд үед дуулагддаг дуунуудыг хатуу дараалалд оруулаад байхгүй. Х. Гүнзэнгийн үзсэнээр «Усан артай хар» (5,4), «Хоо галзан морь» (5,5), «Чилэн сайхан хар» (5,18) дуунууд нь хурим найрыг жаргаах дуунууд юм. Энэ дууг хуримын ёслолоос гарахдаа дуулдаг гэж дөрвөд Х. Гүнзэн тайлбарлажээ. Өнөөдрийг хүртэл хадгалагдан үлдсэн дууны үгэнд асуулт, хариултын хэлбэр ажиглагдана. “Асуулт хэсэг” нь хуримын дуунаас (1, 40) гарсан бөгөөд заримдаа уянгын дуунуудад багтсан байдаг. «Чилэн сайхан хар» (5,18) дуунд “хариулт хэсэг” нь бий.

Чилэн сайхан хар

Чиний нь адуунд байдаг

Чилгэр бичхэн тэр нь

Чиний нь ойр суудаг (1, 40)

Чилэн сайхан хар

Ижил буруу адуунд

Чилгэр ухаатай тэр нь

Элх (элэг) буруу хошуунд (5,18)

Ёс заншлын дагуу гэрлэсэн охин нь жилийн дараа хар морь унан аав, ээжээ эргэж ирдэг. Энэ нь дуунд “Алсад асарлагч уул харагдана — Арван хоёр сар ч алсын газраас хол байна...” гэж дүрслэгджээ. Хуримын дууны бүх хувилбарт баяр хөөртэйгээр зочдоо уриалан “Одоо буцах цаг боллоо” хэмээн хуримын ёслол өндөрлөж буйг мэдэгддэг.

Урьдын цагт уул ус, гол мөрөн, ургамал зэргээс гадна морьдын зүс бүрээр нэрлэгдсэн арван гурван дуу дуулдаг байжээ. “Арван гурван сайхан дууг” баатарлаг туульсын зохиолд найранд дуулж буйгаар гардаг (Владимирцов, 1923: 107).

Нэг бүлгийн арван гурван дууг бүгдийг нь мэддэг дуучин бидний дунд байсангүй. Цуглуулсан материалаа системчлэн нэг бүлгийн дуунуудыг тодруулахыг хичээсэн. Тиймээс бид арван найман нэрээс бүрдсэн “Хээр морь” бүлгийг бий болгов. Хээр морины тухай дуунууд дуучдын дийлэнх олонхийн урын санд байдаг. Зургаа зургаан дууг Намдаг, Пэлжээ нар дуулсан байна. Гүнзэнгийн урын санд ч 6 дуу байна. Хэд хэдэн дууны нэрс дууны өвөрмөц онцлогийг илэрхийлж байна. «Алиа нүдэн хээр» (1,1; 8 7), «Бичхэн хээр» (1,2; 11,2), «Гишгэдэл сайт хээр» (3,2; 5.68), «Жаргалт хээр» (17,3; 20,1), «Хэнзэн сайвар хээр» (15,7; 18,2).

Эхний дуун дээр аргамаг хүлгийн шинжтэй хээр морины дүр төрх, цовоо нүд зэрэг нь илүү тодорхой дүрслэгдсэн байдаг. Дараагийн бадгуудад зүрх сэтгэлээс гарахгүй дурлалт хосуудын дүр, төрсөн нутгийн уул нурууд, өнгө алагласан байгаль нь харагдана. Энэ дууны хувилбараас үзэхэд дууны эхлэлийг хээр морины магтаалаас авсан гэж үзэж болно:

Аргамгийн байдалтай

Алиа нүдэн хээр

Рашаатхан булаг ундтай

Амраг бичхэн тэр нь

Аманд чинь уялга болдов

Гэвч энэ хувилбарыг зохиогч нь морины магтаалын мөрийг өөр дуунд ашигласан байна. Тиймээс хээр морины дууны шүлэгт аавын тухай хоёр мөр нэмж оруулжээ.

Алагтарч харагдана

Алтайс мань нутаг

Амраг бичхэн тэр нь

Аманд чинь уялга болдов

Мөн хээр морины юутай ч зүйрлэшгүй чанарыг бусадтай харьцуулсан байна. (Хорь гаруй шандаст хүлгээс хээрийг минь гүйцэх нь үгүй хоёрын хоёр бэрээчүүдээс ээжийг минь гүйцэх нь үгүй).

Цаашид хээр морины тухай дурдаагүй гэхдээ энэ дуу магтаал шиг сонсогдож байна — (Арван тавны саранд тал газрыг бүрхсэн цэцэгс хойд уулын бэлийг чимнэ). Дөрвөн улирлыг магтан дуулна.

Бичхэн хээр гурван дуунаас эхэлдэг (1,2; 15,8; 16,2). Тэдгээрийн хоёр нь нийтлэг нэг эхлэлтэй ч дууны хоёр хувилбар юм. Ижил агуулгатай шүлэг Г. Бэгзжавын хувилбарт бий.

*Бичхэн чухаа хээр
Хэнийхээ адуунд байхав?
Бичхэн мэлмэгэр тэр минь
Хэнийхээ арганд суунам?*

Гурав дахь дуунд “Бичхэн хээр”-ийн тухай зөвхөн эхний бадагт дуулдаг. Дараа нь хээрийг саарал мориор өөрчилсөн. Бүх бадгийн хоёрдугаар мөр нь “Бүгд хамтдаа жарган сууя” гэжээ.

Өөр бас нэг хээр морины тухай дуу бий (1,3). Алсын замд хань болон ижилдсэн хайртай морио харах төдий бие биенээ ойлгож мэдэрдэг. Монголчууд унаж яваа морио бүхнээс илүү хайрлаж дээдэлдэг. Энэхүү дуунд алс холын нутагт суугаа амраг бүсгүйдээ жаргах нарнаас өмнө очихоор тасам болтол сойсон хүлгээрээ давхиж яваа залуугийн тухай дуулна. Дуунаас хээр морины уяа сойлго таарахад болзооны цаг болж байгааг хэлж байна.

Морь бэлэглэх нь хүндэтгэлийн дээд илэрхийлэл, өгөөмөр сэтгэл юм. Бурхны ёслолын өдрүүдэд сүм хийдээс бурхны баримлыг авч явахдаа бугын баг өмсгөсөн цагаан цээжтэй хээр мориор тэргийг хөллөдөг байжээ. Энэ тухай дуунд:

*Хээр минь болхайя
Хэлбэлзэж ганхана
Хэрэмний сүүл отгыг
Эсхэн авждаан өргөнө (аав ээждээ)
Буга биетэй халтрыг
Бурхны хүлгэнд сойно
Булганы сүүл отгыг
Бурхан авждаан өргөнө (1,4)*

Ухаантай үгтэй энэ дууг анчин хүн зохиосон ба бурхныг хүндэтгэн ангийн олзоо өргөн барьж буй тухай гардаг. Дууны гол утга нь сайн морийг магтан дуулсан явдал юм.

«Гишгэдэл сайтай хээр» (5,68) дуу нь хоёр хувилбартай. Эхний хувилбарыг Б. Мижид зургаан бадаг бичсэн бол хоёр дахь хувилбарыг нь Х. Гүнзэн гурван бадагтай бичжээ.

*Гишгэдэл сайтай хээрийг
Яасан барьж унана
Их бага таньтайгаа
Найрлан сууж жаргана*

*Талган уужим хотлоос
Тасархай бараан харагдана
Танаан болгоод халиахад
Арай түргээр аашина*

*Хөдөө чигээ болоосой
Хөвч нутаг санагдана
Хөгшин чигээ болоосой
Ээж аав минь санагдана*

Эхний хоёр бадаг нь хоёр хувилбарт ижил байна. Мижидийн хувилбарт төрсөн нутагтаа хурдан очихыг хүсч буй хүний дүр төрх гарч ирдэг. Аяншиж ядарсан байдлыг нь өмссөн хувцасны гандсанаар нь илэрхийлжээ.

3. Ойрад ардын дууны онцлогийг алдагдуулалгүй тэмдэглэсэн байдал:

К. Н. Яцковскаягийн цуглуулсан дуунууддаа тулгуурлан зан үйлийн дээрх мэт онцлогийг сайтар судлан бичсэн судлаачийн нөр их хөдөлмөрөөс гадна ойрад аман аялгуу, орон нутгийн өвөрмөц шинжийг илрэхийлсэн дараах хэдэн зүйлийг уг мөн чанарыг нь алдагдуулалгүй тэмдэглэж үлдээсэн байна. Үүнд:

1. Эд эдлэл, хувцас зүүсгэл:

Сувсанлаа сийхээн шаргиулаад

Суусанлаа нутгаан зорино

Тарган хээрээн унаад

Танлай боодгоон шавшуулаад

Таньдаг залуугаан дагуулаад

Тал нутгаан зорино (20.19 Ирэвсалаа хээр)

Үзүүр шар хулс

Үчийн хормой торолзоно

Тохой шар хулс

Тоорцгийн залаа торолзоно

Зах шар хуманд

Заргагын хормой торолзоно (20.7 Харгай сайхан хээр)

Хазаарлая гэсэн хазаар

Хашин мөнгөн хазаар

Дөрөөлье гэсэн дөрөө нь

Дөш мөнгөн дөрөө

Тохьё гэсэн эмээл нь

Тохой зандан бүүрэгтэй

Оломлая гэсэн олом нь

Олхон судастай олом

Жирэмлэе гэсэн жирэм нь

Жирэн судастай жирэм (15.7 Хэнзэн сайвар хээр)

2. Газар усны нэр: Бооржийн эхэн, Төмөр цоргын эхэн, Мөнгөн цоргын эхэн, Ганзагат, Жирэмт (20.17 Бооржийн эхэн), Зэрэгийн шар хулс, Хөх толгой, Хоо толгой (20.14 Зэрэгийн шар хулс) Сөнхөл нуур, Шангас, Үенч, Бодонч, Ангирт (20.13 Сөнхөл нуурын хөвөө), Хэнцэрт, Хоо дэн, Тошилт, Асгат (20.12 Хэнцэрт гэдгийн бэлд), Богд, Заг Байдраг (20.5 Богд хангайн нутаг), Ногоон нуур, Цэгээн нуур (20.1 Жаргалт хээр), Хоёр Алтай, Байрамын эхэн шил, Зүүрэм, Торхилог, Завхан, Хандгайт (8.2 Хоёр Алтай нутаг), Ховдын цагаан түнгэ (5.78 Ижил буруу бор), Хөшөөт нуур, Хуст нуур, Хашаат нуур, Элст нуур (5.41 Даагдах нуурын тогоруу), Хандгайт, Торхилог, Завхан (5.23 Үрээ сайвар зээр), Майгийн эхэн шил, Үенч, Ховд, Байрам (5.22 Хар халтар), Ховог сайр (5.21 Хоёр бороон тарган)

3. Ургамал амьтан: хонгор галуу, ангир галуу, бүргэд, хараадай, элээ, тогоруу, богширго, хөхөө, гарди, шаазгай, хүчгэнэ, улир, марал, бүрээмэг, тэх, гулз, туулай, арслан, ёнхор цэцэг, гишүү, харгай, зандан, тошил, хад, тоорой, яргай, хус, бургас, харгана, тошил, чичэргэнэ, балган, сүхай, нарс, заг, үзэм, давс.

4. Нутгийн аман аялгууны үг:

Аман аялгууны үг:

Рашаатхан булаг ундтай (1.1)
 Эрцэс маны нутаг (1.1)
 Эсхэн авждаан өргөнө (1.4)
 Дэгдмэлийн зулзага хөөрх (1.6)
 Ханилаад мордогсон Ка нар (1.9)
 Хашлай зандан халтар (1.11)
 Хүцэн хүцэн гүйцдэг (1.13)
 Ируу сайхан чишгэнэ (1.31)
 Төөлгөөн дагжим хатирна (1.38)
 Амьдивын адил улаан царайтай (1.45)
 Чийсэн мөөсөн ургана (1.47)
 Сумаараан шуугиад эхтэйм майдар (2.1)
 Аа хаар хуум (2.4)
 Чилэн сайхан хар 5.18
 Сувсан сийхээрээн шагнана (5.20)
 Хайртай бүргэрийн төлөө (5.22)
 Аргас биетэй алагт (5.25)
 Хар шарын торгууд (5.27)
 Өд живрэн гүйцээгээд (20.20)
 Хэнзэлд нь тавигсан тэвгийг чинь
 Шидэрлэн ханилан чамтайгаа (20.9)
 Тухниартай нутаг байвч
 Өөрийн нутаг санагдана (20.8)
 Дөт хангайн нутгаас
 Үүдсэн биш яахав (20.5)
 Наад голын эхэнд
 Нарийхан хур түсэрнэ (20.4)
 Салаа өвөртэй ооныг
 Шархтуулс гэгээд намнана (17.1)
 Туулай сайхан зоо нь
 Сүмийн нургаар адил (15.7)
 Ганцхан чамайгаа бодохоор
 Гарын чимгэн
 Хөлийн чимгэн шархирна (12.1)
 Тасын чимгэн байвч
 Таллаж яаж болхов
 Хүнаан чимгэн байвч
 Хугалж яаж болхов (5.75)
 Зунд чинь зуссан
 Зусмалхан хүрэнгийг
 Зовоож унахад
 Эцэх нь бүрүүтэйе (5.52)
 Алтан мөнгөн байвч
 Амины долиг болно (4.1)

Орчин цагийн монгол хэл:

— рашаантайхан
 — Эрчис
 — аав ээждээ
 — хөөрхий
 — кадр нар, хиа нар, ах нар
 — хашлага
 — урамдах, чичгэнэ
 — төөлөөн
 — амиитаба
 — жимс
 — уулга алдахдаа хэлдэг үг
 — сувдан
 — бүрэг даруу
 — аргаль
 — Харшаарын
 — жигүүрээ
 — хэнз
 — шадарлан
 — тухнууртай
 — уйдсан
 — зүсэрнэ
 — эвэртэй
 — нуруу
 — чөмөг
 — чөмөг
 — буруутай яа
 — золиг

ДҮГНЭЛТ

Монголч эрдэмтэн К. Н. Яцковскаягийн монгол ардын дуугаар цуглуусан эх бичвэрүүд нь академич Б. Я. Владимирцовын Монгол улсын баруун аймгуудаар явж цуглуулсан цагаас хойш бараг 70 гаруй жилийн хойно хийсэн судалгааны ололт бөгөөд энэ нь Баруун монголын ард түмний ардын дууны яруу найраг цаг хугацааны солигдлоос үл хамааран өөрийн өнгө аясаа гээгээгүй байгааг гэрчилсэн хээрийн судалгааны үнэ цэнтэй эх хэрэглэхгдэхүүн мөн билээ.

Монгол аман зохиолд судлалд эргэх холбоо гэж нэг өвөрмөц арга байсан. Судлаач ардын өв тээгчидтэй уулзахдаа хоног хугацаа, цагт баригдах, эсвэл ардын аман зохиол хэлэгчдийн цаг завын боломж бага, нүүдэл суудал, найр хурим таарах, эсвэл хэлж ярих зүйлээ мартаж санах зэрэг зүйл тохивоос эргээд захиагаар холбогдох, уг нутгийн хүнд хэлж үлдээх, санахаараа бичиж захидлаар явуулах зэрэг эргэх холбоо тогтоон ажилладаг байсан сайхан уламжлалыг бид Владимирцов Бурдуковт Парчин туульчаас тууль бичүүлж авснаас, эсвэл Яцковская эргэж захиа бичих зэргээр харилцдаг байсан сайхан уламжлалыг өнөө цагт хэрэглэж болох сайн арга юм. Баруун Монголд ойрадын дууны экспедицийн бичлэг үргэлжилж байна. Сүүлийн үед Ойрадын ардын дууны дээжийг шинжлэн, шинжлэх ухааны эргэлтэд оруулсан хэд хэдэн бүтээл гарч байна (Омакаева, Алимаа, 2009; Омакаева, 2011; Омакаева, Борлыкова, 2014 гэх мэт).

Ном зүй

Владимирцов, Б. Я. (1923). *Монголо-ойратский героический эпос*. Пб. – М.

Омакаева, Э. У., Алимаа, А. (2009). Песенный фольклор монгольских народов: наследие и современность (по материалам полевых исследований 2007 г.). *Фольклор в контексте культуры*: мат-лы Всерос. науч. конф., г. Махачкала, 12 марта 2009 г. Махачкала. 44–47.

Омакаева, Э. У., Борлыкова, Б. Х. (2014). Монгол ба халимаг «Жаңгар» баатарлаг тууль, ардын дуу, бүжиг биелгээ бичиж авах хээрийн судлалгааны еронхий тойм (экспедицийн туршлагаас). *Гадаадын монгол судлаач залу эрдэмтдийн эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл*. Улаанбаатар: Удам соел. 180–189.

Пропп, В. Я. (1976). *Фольклор и действительность*. – М.

Скородумова, Л. Г. (2017). К юбилею Клары Николаевны Яцковской. *Монголика – XIX*. СПб.: Петербургское Востоковедение. 19-24.

Сто песен дархата Г. Давааджия (1978). Публикация, перевод, введение и комментарий К. Н. Яцковской. Москва: Наука.

Яцковская, К. Н. (1974). *Дашидоржийн Нацагдорж: Жизнь и творчество*. М.: Наука.

Яцковская, К. Н. (1982). Образцы из «Синего дэбтэра» народных песен дербетов. *Теоретические проблемы изучения литератур Дальнего Востока*. Тезисы десятой научной конференции (Ленинград, 1982). 2. Москва. 292–294.

Яцковская, К.Н. (1987). Дэбэт Хархуугийн Гунзэн и его песни. *Актуальные проблемы современного монголоведения*. Улан-Батор. 234–239.

Яцковская, К.Н. (1988). *Народные песни монголов*. Москва.

References

Omakayeva, E. U., Alimaa, A. (2009). Pyesyennyi foliklor mongoliskikh narodov: naslyediye i sovremennosti (po materialam polyevykh issledovaniy 2007 g.). *Foliklor v kontyekte kultury: mat-ly Vsyes. nauch. konf., g. Makhachkala, 12 marta 2009 g. Makhachkala. 44–47* (in Russian).

Omakayeva, E. U., Borlykova, B. Kh. (2014). Mongol ba khalimag «Jaṅgar» baatarlag tuuli, ardyn duu, büjig biyelgee bichij avakh kheeriyin sudlalgaany yeronkhii toim (ekspyeditiin turshлагаas). *Gadaadyn mongol sudlaach zaluderdemdiin erdemshinjiigeenii baga khurlyn ilteliin emkhetgel*. Ulaanbaatar: Udam soyol. 180–189 (in Mongolian).

Propp, W. Ya. (1976). *Folklore and reality*. Moscow (in Russian).

Skorodumova, L. G. (2017). K yubileyu Klary Nikolaevna Yatskovskoi. *Mongolia – XIX*. SPb.: Petersburg Vostokovedenie. 19–24 (in Russian).

Sto pesen dakhata G. Davaadjiya (1978). Publication, translation, introduction and comment K. N. Yatskovskaya. Moscow: Nauka (in Mongolian and in Russian).

Vladimirtsov, B. Ya. (1923). *Mongolian-Oirat heroic epic*. Pb.-M. (in Russian)

Yatskovskaya, K. N. (1974). *Dashdorzhiiin Natsagdorzh: Life and work*. M.: Science (in Russian).

Yatskovskaya, K. N. (1982). Samples from the “Blue debter” folk songs of the Derbets. *Theoretical problems of studying the literature of the Far East*. Scientific conference with thesis (Leningrad, 1982). 2. Moscow. 292–294 (in Russian).

Yatskovskaya, K.N. (1987). Derbet Harhuugiin Gunzen and his songs. *Actual problems of modern Mongolian science*. Ulaanbaatar. 234–239 (in Russian).

Yatskovskaya, K.N. (1988). *Mongolian folk songs*. Moscow (in Mongolian and in Russian).